

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ  
ОРШИХ “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-НИЙ ЕВРО БЛОК  
ҮЙЛДВЭРИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хянасан:

“БОУАӨЯ” –ны ХБОБХГ-ын мэргэжилтэн

/...../

“Төв аймгийн БОАЖГ”-ын ахлах мэргэжилтэн

С. Эрдэнэцогт

Хэрэгжилтийг тайлагнасан:

“Монголын алт” (МАК) ХХК  
“Евро блок үйлдвэр”-ийн дарга



Д. Бадамдамдин

Боловсруулсан:

“Монголын алт” МАК (ХХК)-ийн  
“Евро блок үйлдвэр” -ийн Байгаль орчны мэргэжилтэн

Б. Дашням

2024 он

## **ГАРЧИГ**

|                                                                                                   |           |
|---------------------------------------------------------------------------------------------------|-----------|
| <b>1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....</b>                                                           | <b>2</b>  |
| 1.1 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ.....                                                  | <b>10</b> |
| 1.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН<br>ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ.....                     | <b>13</b> |
| <b>2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br/>    ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>             | <b>14</b> |
| <b>3 ОРЧНЫ ТОХИЖИЛТ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БИЕЛЭЛТ<br/>    .....</b>                       | <b>29</b> |
| <b>4 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>    БИЕЛЭЛТ.....</b>                    | <b>31</b> |
| <b>5 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br/>    ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b> | <b>31</b> |
| <b>6 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ<br/>    ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....</b>           | <b>31</b> |
| <b>7 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>    БИЕЛЭЛТ.....</b>                           | <b>31</b> |
| <b>8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>    БИЕЛЭЛТ.....</b>                            | <b>34</b> |
| <b>9 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ.....</b>                                     | <b>37</b> |
| <b>10 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>    БИЕЛЭЛТ.....</b>                        | <b>41</b> |
| <b>11 ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ<br/>    БИЕЛЭЛТ.....</b>                       | <b>43</b> |
| <b>12 ДҮГНЭЛТ.....</b>                                                                            | <b>44</b> |
| <b>ХАВСРАЛТ МАТЕРИАЛУД.....</b>                                                                   | <b>45</b> |

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

**ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУЛГА**

**Компанийн танилцуулга:**

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал үйлдвэрлэл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

**Товч танилцуулга**

Үйлдвэрийн нэр: МАК Евро блок үйлдвэр

Ангилал: Дэд бүтцийн хөгжил

Үйлдвэр эзэмшигчийн нэр: “Монголын Алт” (МАК) ХХК

Улсын бүртгэлийн дугаар: 9011071054

Хаяг: Регистрийн дугаар: 2095025

Хан-Уул дүүрэг, 1-р хороо, XIX хороолол, Чингисийн өргөн чөлөө, “Монголын Алт” (МАК) ХХК-ийн төв байр-44


Утас: 75759700, факс: 70107481

**Хүснэгт 1: Эдэлбэр газрын эргэлтийн цэгүүд**

| №                   | Уртраг (град, мин, сек) | Өргөрөг (град, мин, сек) | Цэг | Зай, м |
|---------------------|-------------------------|--------------------------|-----|--------|
| <b>11 га талбай</b> |                         |                          |     |        |
| 1                   | 107° 12' 40.4 //        | 47° 41' 46.79//          | 1-2 | 598.35 |
| 2                   | 107° 12' 30.49 //       | 47° 42' 4.96//           | 2-3 | 145.74 |
| 3                   | 107° 12' 37.00//        | 47° 42' 6.5//            | 3-4 | 557.41 |
| 4                   | 107° 12' 50.19 //       | 47° 41' 50.78//          | 4-1 | 238.42 |
| <b>1 га талбай</b>  |                         |                          |     |        |
| 1                   | 107° 12' 50.8 //        | 47° 41' 51.01//          | 1-2 | 156.51 |
| 2                   | 107° 12' 47.19 //       | 47° 41' 55.45//          | 2-3 | 61.34  |
| 3                   | 107° 12' 49.81//        | 47° 41' 56.34//          | 3-4 | 149.12 |
| 4                   | 107° 12' 53.6 //        | 47° 41' 52.25//          | 4-1 | 69.88  |

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

**Үйлдвэрийн байршил:** Төв аймгийн Сэргэлэн сум 1-р багт Улаанбаатар хотоос зүүн урагш 40 км зайд, төмөр замын Баян зөрлөгийн дэргэд тус сумын Засаг Даргын 2011 оны 02-р сарын 16-ны өдрийн 19 тоот шийдвэрээр бетоны үйлдвэрлэлийн зориулалтаар 11 га, 2014 оны 06 сарын 13-ны өдрийн 129 тоот шийдвэрээр үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар 1 га, нийт 12 га талбайг эзэмшиж байна.



*Зураг: 1 Талбайн байрлал /google earth/*

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

### **Үйлдвэрийн хүчин чадал**

“Монголын алт” (МАК) ХХК нь “Евро блок үйлдвэр”-т Германы HESS группээс хоногт  $900\text{м}^3$  (цаашид хоногт  $1550\text{м}^3$  болтол өргөтгөх боломжтой) блок үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулсан.

|                             |                       |
|-----------------------------|-----------------------|
| Үйлдвэрийн шугам            | КВТ 900               |
| Хоногт ажиллах ээлжийн тоо: | 2                     |
| Ээлжийн ажиллах хугацаа:    | 12 цаг                |
| Автоклавын циклийн хугацаа: | 12 цаг                |
| Жилд ажиллах өдрийн тоо:    | 300 өдөр              |
| Жилийн хүчин чадал:         | $270\,000\text{ м}^3$ |



**Зураг: 2 Евро блок үйлдвэрийн харагдах байдал**

### **Ажиллах хүч:**

Үйлдвэрийн бүтэц, орон тоо 249 ажилтантай байхаар тусгагдсан ба одоогоор 210 хүн өдрөөр, шөнийн ээлжид 165 ажилчид тус тус ажиллаж байна. Ээлжийн мастер, тоног төхөөрөмжийн оператор, засварчин, тогооч, угаагч, үйлчлэгч гэх мэт тасралтгүй үргэлжилсэн ажилтай хүмүүсийг солигдох ээлжтэй буюу амралттайгаар инженер техникийн ажилчид болон удирдлагууд солигдох ээлжгүйгээр ажиллана.


**Технологийн үйл ажиллагааны үндсэн зарчим:** Евро блок үйлдвэрлэх технологи нь манай оронд байгаа адил төрлийн технологитой харьцуулахад дараах давуу талуудтай. Үүнд:

1. Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, хүчин чадлыг өргөтгөх боломжтой.

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

2. Үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний хэмжээний хэлбэлзлийн хүлцэх алдаа бага ( $\pm 1.5$  мм-ээс ихгүй), нарийвчлал өндөр.
3. Олон улсын болон европын стандартчиллын холбоо (CEM, EN)-ны шаардлагын төвшинд хүрсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой.
4. Бүтээгдэхүүний сав баглаа, боодлыг олон улсын шаардлагын хэмжээнд шийдвэрлэсэн.
5. Бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, зүсэх ажиллагааны технологийн зохицолдолгооны шийдэл сайтай.
6. Даацын арматуртай эдлэхүүн үйлдвэрлэх, барилгын даац, дулаан тусгаарлалтын бүх бүтээц, элементийг үйлдвэрлэх шинэ шугамыг 2018 оны 4 сард ашиглалтанд оруулсан.

**Схем: 1 Үйлдвэрийн технологи**



**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

**Төслийн тоног төхөөрөмж, техник болон дэд бүтэц**

**Тоног төхөөрөмж:** Германы HESS группээс хоногт 900м<sup>3</sup> (цаашид хоногт 1550м<sup>3</sup> болтол өргөтгөх боломжтой) Евро блок үйлдвэрлэх КВТ 900 үйлдвэрийн шугамыг суурилуулсан.

**Цахилгаан, хангамж:** Үйлдвэрийн цахилгааны суурилагдсан хүчин чадал 3.2МВт, үйлдвэрийн хүчдэл 400+5% VAC, 3 фаз + PE, 50Гц ±5%.

**Хүснэгт: 2 Цахилгааны хэрэглээ**

| Цахилгааны хэрэглээ, кВт*Ц | 1 м <sup>3</sup> Хийт бетонд | Жилийн хэрэглээ<br>кВт-900 |
|----------------------------|------------------------------|----------------------------|
|                            | 19.5                         | 7,680,000                  |

Үйлдвэрээс 16.6 км зайд байрлах Налайхын дэд станцаас 35 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татан үйлдвэрт шаардлагатай цахилгааны хэрэглээг хангаж байна



**Зураг 3: Цахилгааны 35/0,4 кВ-ын дэд станц**

**Зам тээвэр:** Улаанбаатар хотоос 45 км, Налайх дүүргээс 10 км зайтай Улаанбаатар – Замын үүд чиглэлийн олон улсын чанартай автозамаас 700 метр авто замаар явж хүрнэ.

Үйлдвэрийн түүхий эд болон бэлэн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн нөхцөлийг доорх хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 3: Тээвэрлэлтийн нөхцөл**

| Материал | Хэмж<br>их<br>нэгж | Зай,км | Тээврийн<br>хэрэгсэл | Тээвэрлэх хэмжээ |          | Тайлбар                                  |
|----------|--------------------|--------|----------------------|------------------|----------|------------------------------------------|
|          |                    |        |                      | Хоногт           | 7 хоногт |                                          |
| Элс      | тн                 | 35     | Авто машин           | 15               | 102      | Дэнжийн элсний орд,<br>Налайх            |
| Шохой    | тн                 | 280    | Галттэрэг            | 1                | 7        | МАК-ын цементийн<br>үйлдвэр, 25-р зөрлөг |

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

|          |    |         |                       |                |                 |                                               |
|----------|----|---------|-----------------------|----------------|-----------------|-----------------------------------------------|
| Цемент   | тн | 280     | Галт тэрэг            | 2              | 12              | МАК-ын шохойн үйлдвэр, 25-р зөрлөг            |
| Гөлтгөнө | тн | 280     | Галт тэрэг, автомашин | 0              | 2               | Ширээгийн хөндийн гөлтгөнийн орд, 25-р зөрлөг |
| Нүүрс    | тн | 10, 450 | Галт тэрэг, автомашин | 37,1тн<br>12,8 | 4 вагон<br>90тн | Хөөтийн уурхай                                |

**Төслийн түүхий эд, туслах материал, эцсийн бүтээгдэхүүн**

**Байгалийн гаралтай түүхий эд:**

Манай үйлдвэрийн үйл ажиллагаанд байгалийн баялгаас ус, элс хэрэглэгдэнэ.

**Элс:** Налайх дүүрэгт байрлах Дэнжийн элс-1 ордоос автомашинаар тээвэрлэн ирсэн элсийг үйлдвэр доторх агуулахад хадгалах ба шанагат ачигчаар элс түр хадгалах бункерт өгч туузан дамжуулагчаар дамжуулан бөмбөлөгт тээрэмд ачаална.

**Шохой:** Евро блок үйлдвэр хоногт 62 тн шохой хэрэглэх бөгөөд шохойг Хөтөл ХК-ийн шохойн үйлдвэрээс галт тэргээр тээвэрлэнэ. Галт тэргээр хүлээн авсан шохойг ус чийгээс хамгаалсан битүүмжлэлтэй агуулахад хадгалах бөгөөд технологийн шохойг урьдчилан буталсны дараа бөмбөлөгт тээрэмд тээрэмдэж зохих хувийн гадаргуутай болтол нунтаглан ажлын силост хадгална.



***Зураг :4 Шохой хадгалах битүү агуулах***

**Гөлтгөнө:** Евро блок үйлдвэр хоногт 19 тн гөлтгөнө хэрэглэх бөгөөд үйлдвэрт шаардлагатай гөлтгөнийг МАК-ын цементийн үйлдвэрээс галт тэргээр болон автомашинаар тээвэрлэнэ гэж тооцвол 7 хоногт 2 вагон гөлтгөнө хэрэглэнэ. Галт тэргэнээс хүлээн авсан гөлтгөнийг задгай агуулахад хадгалах бөгөөд 5мм-ээс жижиг ширхэгтэй болтол урьдчилан буталж тугнасны дараа бөмбөлөгт тээрэмд элстэй хамт өгч нунтаглана.

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**



**Зураг: 5 Гөлтгөнө хадгалах задгай талбай**

**Нүүрс:** Хөөтийн уурхайн нүүрсийг хэрэглэх бөгөөд нүүрсний илчлэг 3400-3500 ккал/кг, ба чийглэг 8.5%, үнслэг 10-33.3%, дэгдэмхий бодисын агуулга 22.0-34.1% байна. 1 өдрийн хугацаанд нүүрсний зарцуулалт өдөрт 6 тонн 1 сарын хугацаанд 180 тн байна.

**Ус:** Евро блок үйлдвэрлэхэд хэрэглэх ус нь ямар нэгэн хортой хольц агуулаагүй рН нь 7-8.3 байна.

**Бусад түүхий эд**

Бусад түүхий эдэд цемент, хөнгөн цагааны нунтаг орно.

**Цемент:** Евро блок үйлдвэр хоногт 89 тонн цемент хэрэглэх бөгөөд цементийг МАК-ийн цементийн үйлдвэрээс галт тэргээр тээвэрлэнэ. Галт тэргээр хүлээн авсан задгай цементийг хийн тээврийн төхөөрөмжөөр буулган цементийн силост (агуулахад) хадгална. Цементийн силосоос ажлын силос руу хийн тээврээр тээвэрлэн тугнаж хэрэглэнэ.




**Зураг: 6 Цемент буулгах хэсэг болон хадгалах силос**

**Хөнгөн цагааны нунтаг:** Үйлдвэр нь жилд 80 тн хөнгөн цагааны нунтагийг худалдан авч тусгай агуулахад хадгалдаг бөгөөд агуулахыг “MNS 6458:2014 Химийн хорт бодис бүтээгдэхүүний агуулах, ерөнхий шаардлага”-д нийцүүлэн байгуулсан. Тус агуулахад зөвхөн

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

мэргэшсэн ажилтан орох зөвшөөрөлтэй бөгөөд нунтаг хөнгөн цагаан нь битүү дамжуулгаар зөөгдөн түүхий эдийн хольц бэлтгэх хэсэгт өгөгддөг.



**Зураг:7 Химийн бодис ашиглах зөвшөөрөл**



**Зураг:8 Агуулах**

**Эцсийн бүтээгдэхүүн:**

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэр” нь хоногт 292 тн элс, 62 тн шохой, 89 тн цемент, 18 тн гөлтгөнөөр 900м<sup>3</sup> бетон үйлдвэрлэнэ.

**Хүснэгт:4 Түүхий эдийн хэрэглээ**

| Түүхий эд<br>материалын нэр | Хэмжих<br>нэгж | Хэрэглээ |          |
|-----------------------------|----------------|----------|----------|
|                             |                | Хоногт   | 7 хоногт |
| Элс                         | тн             | 292.0    | 2044     |
| Шохой                       | тн             | 62.0     | 434      |
| Цемент                      | тн             | 89.0     | 693      |
| Гөлтгөнө                    | тн             | 18.0     | 126      |
| Хийт бетон,                 | м <sup>3</sup> | 900      | 6300     |

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**



**Зураг:9 Бэлэн бүтээгдэхүүн**

**Нэгдсэн менежментийн тогтолцоо:** Манай үйлдвэр нь 2022 оны 12 сарын 30 нд **ISO 9001:2015** “Чанарын менежментийн тогтолцоо”, **ISO 45001:2018** “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо”, **ISO 14001:2015** Байгаль орчны менежментийн тогтолцоо олон улсын стандартуудын аудитаа амжилттай хамгаалж баталгаажуулалтын гэрчилгээг гардан авч нэгдсэн менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна.



**Зураг:10 Нэгдсэн менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээ**

### 1.1 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Евро блок үйлдвэрийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг 2021 оны БОННУ-ний нэмэлт тодотголоор дараах байдлаар тодорхойлсон байдаг. Байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өртөгдлийн байдал. Төсөл хэрэгжих явцад байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон гол нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчим зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг.

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

*Хүснэгт: 5 Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл*

| №                                      | Бохирдол,<br>нөлөөлөл                                 | Нөлөөллийн эх үүсвэл /үйл<br>ажиллагаа/                                                                                                                           | Нөлөөллийн шинж чанар,<br>өртөгдлийн байдал                                                                                                                                                                                 |
|----------------------------------------|-------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1                                      | 2                                                     | 3                                                                                                                                                                 | 4                                                                                                                                                                                                                           |
| <b>Нэг. Орчин</b>                      |                                                       |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                             |
| 1.1                                    | Тоосжилт                                              | Түүхий эдийг тээвэрлэх зөөх,<br>үйлдвэрийн бутлах,тээрэмдэх<br>хэсэг                                                                                              | Үйлдвэрийн гадна болон доторх<br>агаар орчинд тархах, ажилчдын<br>эрүүл мэндийн байдалд нөлөөлнө.                                                                                                                           |
| 1.2                                    | Дотоод<br>шаталтын<br>хөдөлгүүрийн<br>хорт хий, угаар | Тээвэрлэлтэнд хэрэглэгдэх машин,<br>механизм                                                                                                                      | Агаар орчинд тархах боловч<br>хадгалагдах болон тархах хүрээ<br>хязгаарлагдмал                                                                                                                                              |
| <b>Хоёр. Усан орчин</b>                |                                                       |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                             |
| 2.1                                    | Хатуу болон<br>шингэн<br>хаягдал                      | Ахуйн болон шатах тослох<br>материалын хаягдал<br>Тээвэрлэлтийн явцад техникийн<br>бүрэн бус байдал, хүмүүсийн<br>анхаарал хайхрамжгүйн улмаас<br>асгарах, гоожих | Хур борооны усаар угаагдаж хөрс,<br>гүний ус бохирдуулна                                                                                                                                                                    |
| <b>Гурав. Хөрс</b>                     |                                                       |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                             |
| 3.1                                    | Эвдрэл                                                | Цементийн агуулахын барилга<br>барих, засвар шинэчлэл хийх үед<br>суурь ухах хөрс эвдэгдэх,<br>овоолгод дарагдах, дагтарших,<br>талхлагдах                        | Хөрсний физик механик шинж<br>чанарт өөрчлөлт орж болно.<br>Барилгын ажлын дараа нөхөн сэргээх<br>боломжтой                                                                                                                 |
| 3.2                                    | Бохирдол                                              | Шатах тослох материалын болон<br>ахуйн хог хаягдал                                                                                                                | Бохирдлоос сэргийлэх, нөхөн сэргээх<br>боломжтой<br>Хэмжээ хязгаарлагдмал<br>Хөрс бохирдсоноос хөрсний<br>микробиологийн шинж чанарт<br>өөрчлөлт орж болно.<br>Шавьж хорхой байршлаа сэлгэх,<br>хордох, үхэж үрэгдэж болно. |
| <b>Дөрөв. Ургамал бүрхэвч</b>          |                                                       |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                             |
| 4.1                                    | Газар шорооны<br>ажлын үед                            | Ургамлан бүрхэвч бүхэлдээ<br>устгагдах, дарагдах байдлаар үгүй<br>болно.                                                                                          | Хэмжээ хязгаарлагдмал<br>Төрөл, зүйл устаж, өөрчлөгдөж<br>болно.                                                                                                                                                            |
| 4.2                                    | Хордолт                                               | Ахуйн хог болон шатах тослох<br>материалын хаягдал                                                                                                                | Хэмжээ хязгаарлагдмал<br>Ургамал эргэлт буцалтгүй устаж<br>болно.<br>Удамшил генд өөрчлөлт орж болно.                                                                                                                       |
| 4.3                                    | Талхлагдах                                            | Хүний хөл, үйл ажиллагаанд<br>байнга өртөж буй зөрөг зам, жим,<br>талбай ашиглалтын орчин                                                                         | Биомассын хэмжээ багасна<br>Төрөл зүйл устаж болно.<br>Нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж<br>болно.                                                                                                                           |
| <b>Тав. Нийгэм эдийн засгийн орчин</b> |                                                       |                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                             |

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

|     |                                   |                                                                |                                                                                                                                    |
|-----|-----------------------------------|----------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 5.1 | Эко<br>бүтээгдэхүүн<br>үйлдвэрлэл | Байгаль орчинд ээлтэй технологи<br>нэвтрүүлэх                  | Орчин үеийн чанарын шаардлага<br>хангасан, дэвшилтэт технологи<br>бүхий барилгын материалаар зах<br>зээлийн эрэлт хэрэгцээг хангах |
| 5.2 | Шинээр<br>ажиллагсад<br>авна      | Эдийн засгийн чадавх дээшилнэ.<br>Ажлын байр шинээр бий болно. | Тогтмол                                                                                                                            |

Төсөл хэрэгжих явцад байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр,эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх эсэхийг болон гол нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчим зэргийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэдэг.

**Хүснэгт: 6**

| Байгаль орчны үзүүлэлт                                                                     | Хэлбэр |          |                     | Үргэлжлэх хугацаа |        |                |           | Эрчим  |            |            |
|--------------------------------------------------------------------------------------------|--------|----------|---------------------|-------------------|--------|----------------|-----------|--------|------------|------------|
|                                                                                            | Шууд   | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Урт хугацааны     | Богино | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
| <b>1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал</b>                               |        |          |                     |                   |        |                |           |        |            |            |
| Гүний усны нөөцөд нөлөө үзүүлэх                                                            | х      |          |                     | х                 |        |                |           |        |            | х          |
| Хөрс, ургамлын талхагдал                                                                   | х      |          |                     |                   | х      |                |           |        | х          |            |
| Агаарын орчинд нөлөөлөх                                                                    | х      |          |                     |                   | х      |                |           | х      |            |            |
| Хээрийн түймрийн аюулд өртөх                                                               | х      |          |                     |                   | х      |                |           | х      |            |            |
| Тоосонцорын бохирдол                                                                       | х      |          |                     |                   | х      |                |           |        | х          |            |
| <b>2. Төслийн үйл ажиллагаатай холбоотой байгаль орчны асуудал</b>                         |        |          |                     |                   |        |                |           |        |            |            |
| Үйлдвэрийн ажиллагаанд хэрэглэх химийн бодис, тос тослох материалууд хөрсөнд үзүүлэх нөлөө | х      |          |                     | х                 |        |                |           |        | х          |            |
| Машин механизмын үйлчлэлээр байгаль орчин нөлөөлөх нөлөөлөл                                | х      |          |                     |                   | х      |                |           |        | х          |            |
| Усан орчинд үзүүлэх нөлөө /гүний/                                                          | х      |          |                     | х                 |        |                |           |        |            | х          |
| Төслийн үйл ажиллагаанаасүүсгэх дуу шуугианы нөлөө                                         | х      |          |                     |                   | х      |                |           |        | х          |            |
| Тоосонцроос үзүүлэх нөлөө                                                                  | х      |          |                     |                   | х      |                |           |        | х          |            |
| Дулааны хэрэглээнээс үзүүлэх нөлөө /уурын зуух/                                            | х      |          |                     |                   |        |                | х         |        | х          |            |
| <b>3. Байгалийн нөөц ашиглалт</b>                                                          |        |          |                     |                   |        |                |           |        |            |            |
| Гүний ус                                                                                   |        | х        |                     |                   | х      |                |           |        | х          |            |
| Элс                                                                                        | х      |          |                     |                   | х      |                |           |        |            | х          |
| Гөлтгөнө                                                                                   | х      |          |                     |                   | х      |                |           |        |            | х          |
| Нүүрс                                                                                      | х      |          |                     |                   | х      |                |           |        | х          |            |

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

|                                                                                           |           |          |          |          |           |          |           |          |           |           |
|-------------------------------------------------------------------------------------------|-----------|----------|----------|----------|-----------|----------|-----------|----------|-----------|-----------|
| Хур тунадсаар хуримтлагдах усны хэрэглээ                                                  |           | x        |          |          | x         |          |           |          |           | x         |
| Хөрсний үржил                                                                             |           | x        |          |          |           |          | x         |          |           | x         |
| <b>4. Байгаль орчны өөрчлөлт</b>                                                          |           |          |          |          |           |          |           |          |           |           |
| Ундны усны чанар, хэмжээ /гүний/                                                          |           | x        |          |          |           |          |           |          |           | x         |
| Хөрсний элэгдэл, бохирдол                                                                 | x         |          |          | x        |           |          |           |          | x         |           |
| Агаарын бохирдол                                                                          | x         |          |          |          |           |          | x         |          | x         |           |
| Ургамлын төрөл зүйлийн устгал                                                             | x         |          |          | x        |           |          |           |          | x         |           |
| <b>5. Нийгэм эдийн засгийн асуудал</b>                                                    |           |          |          |          |           |          |           |          |           |           |
| Хувийн өмчийн болон татварын орлого нэмэгдэх                                              | x         |          |          |          | x         |          |           |          | x         |           |
| Орон нутгийн орлого нэмэгдэх                                                              | x         |          |          |          | x         |          |           |          | x         |           |
| Ажлын байр нэмэгдэх                                                                       | x         |          |          | x        |           |          |           |          | x         |           |
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх                                                  | x         |          |          |          | x         |          |           |          |           | x         |
| <b>6. Бусад асуудал</b>                                                                   |           |          |          |          |           |          |           |          |           |           |
| Хөрсөнд үзүүлэх туслах материалын нөлөө                                                   | x         |          |          |          | x         |          |           | x        |           |           |
| Чимээ шуугианы нөлөө                                                                      |           | x        |          |          | x         |          |           |          |           | x         |
| Болгоомжгүйгээс гал түймэр гарах                                                          |           | x        |          |          | x         |          |           | x        |           |           |
| Хүчтэй буюу аадар борооны улмаас үер болох                                                | x         |          |          |          | x         |          |           | x        |           |           |
| Хатуу, шингэн хог хаягдал ихсэх                                                           | x         |          |          | x        |           |          |           |          |           | x         |
| Химийн бодис болон нефтийн бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт муугаас хөрс, ус бохирдох | x         |          |          | x        |           |          |           |          | x         |           |
| <b>Дүн</b>                                                                                | <b>25</b> | <b>6</b> | <b>-</b> | <b>8</b> | <b>19</b> | <b>-</b> | <b>3-</b> | <b>5</b> | <b>16</b> | <b>10</b> |

Тайлбар: x-болзошгүй нөлөөлөл, бөглөгдөөгүй нь тухайн төсөлд хамааралгүй.

## **1.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ**

Үйлдвэр нь 2024 онд 321,600 м<sup>3</sup> бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөсөн бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ.

Үүнд:

- БОННУ-ний тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг төлөвлөн хэрэгжүүлснээр байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалах, хамгаалах
- Монгол улсын Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах.
- Байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арилгах талаар заавар зааварчилгааг ажиллагсад сургалтын хэлбэрээр өгөх.

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

- Аймаг, сумын удирдлага, хяналтын байгууллага, багийн ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж тэдний саналыг авч хамтран ажиллах.
- Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх
- Байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах

## **2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

### **2.1 Агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийсэн ажлууд:**

**2.1.1** Тоосжилт үүсэж буй түүхий эд буулгах талбай болон, блок бутлуур, хогийн цэгийн хэсэгт салхины хүчийг сааруулж, орчинд тоосжилт тархахаас сэргийлэн түүхий эд буулгах талбайд 130 метр урттай, 7 метр өндөртэй, бутлуур, хогийн цэгийн хэсэгт 7 метрийн өндөртэй 158 метр урттай бетонон суурьтай салхины хаалтыг 2023 онд хийж гүйцэтгэсэн ба энэ жил нэмэлтээр бутлуурын хэсэгт нэмэлт битүүмжлэлийг хийж өгсөн. Ингэснээр бутлуураас үүсэх тоосжилтын хэмжээг багасгаж агаарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж ажиллалаа.



*Зураг:11 Хогийн цэг болон блок бутлуурын хэсгийн хаалт*


**2.1.2** Агаарын чанарын мониторингийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлын хүрээнд: БОННУ-нд заагдсаны дагуу 4 цэгт улирал тутам Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор агаарын чанарын хэмжилтийг гүйцэтгүүлсэн ба өмнөх оны хэмжилтийн дүнтэй харьцуулж үзэхэд тоос болон хүхэрлэг хий, азотын давхар ислийн үзүүлэлт буурсан байна. Үүнд :

1. ЕВ-А-1 (Түүхий эд буулгах талбай)
2. ЕВ-А-2 (Хогийн цэг, ачилтын талбай)
3. ЕВ-А-3 (Бутлуур тээрмийн хэсэг)
4. ЕВ-А-4 (Уурын зуух орчим)


**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

**Итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүн**

*График 1 2023 оны сорилтын дүн*



*График 2 2024 оны сорилтын дүн*



Дээрх хэмжилтийн дүнгээр үзэхэд агаар бохирдуулагч бодисын хэмжээ Монгол улсын агаарын чанарын стандарт MNS 4585:2016 болон Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ажлын байрны орчин MNS 4990:2010, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага стандартуудыг хангаж, бохирдуулагч бодисын хэмжээ хүлцэх хэмжээнээс бага байна.

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

**2.1.3 Агаарын чанарын мониторингийг өөрийн багажаар хийх ажлын хүрээнд:**

Үйлдвэрийн агаарын чанарын хэмжилтийг батлагдсан хуваарийн дагуу PCE-EM882, PCE-RCM 10 багажуудаар 12 цэгт 5 минутын давтамжтай хийж гүйцэтгэсэн.

**PCE-EM882** багажаар гэрэл, температур, чийг, дуу чимээ, **PCE-RCM 10** багажаар Агаарын тоос /PM 2.5, PM 10/ хэмжилтийг хийж Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага MNS:4585:2016, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэнд ажлын байрны орчин, Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэнд шуугианы норм, Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 5002:2000 стандартуудтай харьцуулж тодорхойлов.

***Хүснэгт:7 Дотоодын багажаар хийсэн хэмжилтийн дүн***

| №  | Сорьц авсан цэг          | Тодорхойлсон утгууд |                 |                 |                 |              |                 |             |                 |       |                 |      |                 |
|----|--------------------------|---------------------|-----------------|-----------------|-----------------|--------------|-----------------|-------------|-----------------|-------|-----------------|------|-----------------|
|    |                          | Дуу чимээ /db/      | Стандарт хэмжээ | Температур /Т / | Стандарт хэмжээ | Чийгшил /RH/ | Стандарт хэмжээ | Гэрэл /LUX/ | Стандарт хэмжээ | PM2.5 | Стандарт хэмжээ | PM10 | Стандарт хэмжээ |
| 1  | Түүхий эд буулгах талбай | 68                  | 85              | 17.4            | -               | 30.4         | 30-60           | 1557        | -               | 25    | 50-25           | 41   | 100-50          |
| 2  | Шохойн тээрэм            | 88.5                | 85              | 26.5            | 18-22           | 23.9         | 30-60           | 469         | 150-300         | 15    | 50-25           | 30   | 100-50          |
| 3  | Бөмбөлөгт тээрэм         | 87.5-88             | 85              | 16.3            | 18-22           | 42           | 30-60           | 240         | 150-300         | 65    | 50-25           | 128  | 100-50          |
| 4  | Цамхаг орчим             | 78-80.3             | 85              | 26.8            | 18-22           | 37           | 30-60           | 144.5       | 50-150          | 25    | 50-25           | 52   | 100-50          |
| 5  | Уурын зуух               | 80                  | 85              | 21.3            | 18-22           | 36           | 30-60           | 80          | 50-150          | 58    | 50-25           | 100  | 100-50          |
| 6  | Автоклавын хэсэг         | 70.5-76.5           | 85              | 26.9            | 18-22           | 40.6         | 30-60           | 50          | 50-150          | 52    | 50-25           | 127  | 100-50          |
| 7  | Хөөлгөх хэсэг дотор      | 60-70               | 85              | 33.1            | 18-22           | 34.5         | 30-60           | 130.5       | 50-150          | 47    | 50-25           | 100  | 100-50          |
| 8  | Блокны уур               | 68-75               | 85              | 23.6            | 18-22           | 53.4         | 30-60           | 128         | 50-150          | 15    |                 | 30   | 100-50          |
| 9  | Үйлдвэрийн гадна талбай  | 45-50               | 60              | 23.6            | 18-22           | 31.8         | 30-60           | 1600        | -               | 18    | 50-25           | 13   | 100-50          |
| 10 | Оффис                    | 48.8-50             | 60              | 21.5            | 18-22           | 38.7         | 30-60           | 240         | 150-300         | 9     | 50-25           | 20   | 100-50          |
| 11 | Гал тогоо                | 58-62               | 60              | 23.1            | 18-22           | 36.4         | 30-60           | 132         | 150-300         | 52    | 50-25           | 105  | 100-50          |
| 12 | Лаборатори               | 56-58.3             | 60              | 25.6            | 18-22           | 38           | 30-60           | 150         | 150-300         | 60    | 50-25           | 156  | 100-50          |

**2.2 ГАЗРЫН ГАДАРГА ХӨРСӨН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ  
БУУРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД**

2024 онд үйлдвэрийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

**2.2.1 Зүлэгжүүлэх ажил:** 2024 онд үйлдвэрийн нийт зүлэгжүүлсэн талбайн шаардлагатай газруудад нөхөн тарилт болон шинээр зүлэг тарих ажлыг 900 м<sup>2</sup> талбайд хийж гүйцэтгэсэн.

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**



*Зураг:12 Тарилтын үеийн зураг*

**2.2.2 Хогийн цэгийн ашиглалтад хяналт тавьж ажиллах:** Үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, устгах зорилгоор төрөлжүүлэн ангилан ялгах боломжтой түр хогийн цэг болон аюултай хог хаягдал хадгалах талбайн ашиглалтад тогтмол хяналт тавьж тэмдэг тэмдэглэгээг сайжруулан газрын гадарга хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж ажиллалаа.

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**




*Зураг:13 Хогийн цэгийн ашиглалт, тэмдэг тэмдэглэгээ*

**2.2.3 Мод тарих:** Бүх нийтээр мод тарих өдөр "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд болон БОМТ-д тусгагдсаны дагуу өөрийн эзэмшил талбайн ШНБ зүүн, баруун тал, үйлдвэрийн зүүн тал, бэлэн бүтээгдэхүүний агуулах, Дэд станцын урд талбайд шар хуайс 200 ш, хайлаас 175 ш, монос 40 ш, нарс 25 ш нийт 440 ширхэг. Сэргэлэн сумын засаг даргын тамгын газар Сургууль, Цэцэрлэгийн талбайд МАК Евро Виндоор үйлдвэртэй хамтран 100 ширхэг гацуур нийт 540 ширхэг мод бутыг тарьж ургууллаа.



**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**





*Зураг:14 Тарилтын явц*

#### **2.2.4 Хөрсний мониторинг хийх ажлын хүрээнд:**

Үйлдвэр нь хүнд машин механизмын засвар, үйлчилгээ, тээврийн хэрэгслүүдээс асгаралт үүсэж газрын гадарга хөрсөн бүрхэвчид бохирдол үүсгэхээс урьдчилан сэргийлэн засвар үйлчилгээг тогтмол зориулалтын талбайд хийж тос масло асгарахаас сэргийлэн зориулалтын сав тосож засвар үйлчилгээг хийж байна Хөрсөнд тос масло асгарсан тохиолдолд тухай бүр нь Аюултай хог хаягдал алдагдсан тохиолдолд авах арга хэмжээний журмын дагуу мэдээлэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлж бохирдсон хөрс болон бусад материалыг аюултай хог хаягдал хадгалах талбай болон хөрс саармагжуулах талбайд хадгалж эзэмшил газрын хэмжээнд болон ойр орчимд бохирдол үүсэхээс сэргийлэн ажиллаж байна. Мөн үйлдвэрийн хог хаягдлыг түр хадгалах цэг болон эргэн тойрон, блок бутлуурын хэсэг бэлэн бүтээгдэхүүн хадгалах талбайг бүрэн хатуу хучилттай болгож салхины хүчийг сааруулах хашаа, хаалт хийж түүхий эд буулгах болон хадгалах талбайн битүүмжлэлийг хийж газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж ажиллалаа.


БОННУ-д заасан хуваарийн дагуу улирал тутам хогийн цэг болон бүтээгдэхүүн хадгалах талбайн зонхилох салхины дор, түүхий эд буулгах талбай, бохирын цооног орчим хүнд металлын бохирдол үүсэж байгаа эсэхийг тогтоох зорилгоор итгэмжлэгдсэн лаборатори болох Байгаль орчин хэмжил зүйн төв лабораториор холбогдох стагдартуудын дагуу улирал тутам шинжлүүлсэн. Шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсөн дэх хүнд металлын агууламж нь MNS5850:2008 стандартаас давсан үзүүлэлт байхгүй үйлдвэрийн хөрс хүнд металаар бохирдоогүй хэмээн үзэж байна./ *Шинжилгээний дүнг тайланд хавсаргав.*

**“Монголын Алт” (МАК) ХХК-ийн “Евро блок үйлдвэрийн” 2024  
оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт-ийн тайлан**

**Хүснэгт: 8 Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн**

